МЭДЭЭ · 2026 оны 2-р сарын 16

КИБЕР ОРЧИНД ХУУЛЬ БУСААР ХАЛДСАН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 48,710 эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллажээ. Дээрх хугацаанд 1,589 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 763 хэрэг шинээр нээж, 383 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 179, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 92, Өмчлөх эрхийн эсрэг 73, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг тус бүр 7, Авлигын эсрэг 5, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг 4, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг 3, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг, Эдийн засгийн гэмт хэрэг тус 2 байна.



Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

- С.Г нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа өөрт холбогдох зөрчлийн хэргийг удаашруулах ашиг сонирхлын үүднээс өөртөө давуу байдал бий болгох зорилгоор зөрчил шалган шийдвэрлэж буй албан хаагчид хахууль өгсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 2 /Хахууль өгөх/-д зааснаар, түүнээс хахууль авсан О.Ж-д Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 /Нийтийн албан тушаалтан хахууль авах/-д зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- М.М нар нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, байгууллагын данснаас бараа материал худалдан авсан мэтээр нэр бүхий компани руу шилжүүлсэн мөнгийг бусад иргэний дансаар дамжуулан авч өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Б.М нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулдаг худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад зохих журмын дагуу хамрагдалгүй, шалгалтад тэнцсэн мэтээр гэрчилгээг гаргуулан авч өөртөө давуу байдал бий болгох ашиг сонирхлын үүднээс бусдад хахууль өгсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйлийн 1 /Хахууль өгөх/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд,

- Б.А нь Монгол Улсад “iptv”-ийн үйлчилгээ үзүүлэгч платформын хамгаалалтын

системийг эвдэж, 30 гаруй төрлийн кино, контент хуулбарлаж, телеграмм хуудсанд байршуулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлийн 2 /Кибер орчинд хууль бусаар халдах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дүүргийн Эрүү, иргэний хялбар ажиллагааны тойргийн шүүхэд

- А.А нь Монгол Улсад “iptv”-ийн үйлчилгээ үзүүлэгч платформын хамгаалалтын системийг эвдэж, 130 гаруй төрлийн кино, контент хуулбарлаж телеграмм хуудсанд байршуулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлийн 2 /Кибер орчинд хууль бусаар халдах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дорнод аймаг дахь сум дундын анхан шатны тойргийн шүүхэд,

- Г.Э нь НҮБ-ын 1961 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцын I жагсаалтад багтдаг каннабисын ургамлын мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисыг гадаад улсаас захиалж олон улсын шуудан илгээмжийн газраар дамжуулан Монгол Улсын хилээр нэвтрүүлж, хууль бусаар олж авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 3.3 /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд тус тус шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/634